XXV.1.23	Эмнэлгийн барилга, 10 ор /Завхан, Асгат сум/	2013	2014	1,014.6	414.6
XXV.1.24	Эмнэлгийн барилга, 10 ор /Дундговь, Адаацаг сум/	2013	2014	861.1	361.1
XXV.1.25	Байгалийн голомтот халдварт өвчинтэй тэмцэх газрын барилга /Хэнтий, Хэрлэн сум/	2013	2015	618.5	118.5
XXV.1.26	Эмнэлгийн барилга, 10 ор /Архангай, Батцэнгэл сум/	2013	2014	1,132.6	1,047.1
	Дутуу санхүүжилт			15,642.6	2,600.2
XXV.1.27	Төрөх эмнэлэг, 50 ор /Говь-Алтай, Есөнбулаг сум/	2013	2014	1,888.8	75.1
XXV.1.28	Сэтгэцийн эмгэг судлалын үндэсний төвийн барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2013	2014	4,101.4	901.4
XXV.1.29	Эмнэлгийн барилга, 10 ор /Өвөрхангай, Бүрд сум/	2013	2014	447.8	247.8
XXV.1.30	Эмнэлгийн барилга, 10 ор /Хөвсгөл, Баянзүрх сум/	2013	2014	616.0	136.0



XXV.1.31	Эмнэлгийн барилга, 10 ор /Сэлэнгэ, Мандал сум, Хэрх тосгон/	2013	2014	582.0	122.0
XXV.1.32	Эмнэлгийн барилга, 10 ор /Баянхонгор, Баян-Өндөр сум/	2013	2014	624.7	60.0
XXV.1.33	Эрүүл мэндийг дэмжих төв /Говь-Алтай, Есөнбулаг сум/	2013	2014	610.1	28.5
XXV.1.34	Эмнэлгийн барилга, 10 ор /Дундговь, Дэлгэрцогт сум/	2013	2014	811.1	311.1
XXV.1.35	Халдвартын эмнэлгийн барилга, 30 ор /Завхан, Улиастай сум/	2013	2014	1,446.0	248.0
XXV.1.36	Эрүүл мэндийг дэмжих төв /Орхон, Баян-Өндөр сум/	2013	2014	820.5	86.5
XXV.1.37	Бүсийн оношилгоо, эмчилгээний төв /Өвөрхангай, Арвайхээр сум/	2013	2014	1,354.5	64.5
XXV.1.38	Эмнэлгийн барилга, 20 ор /Сүхбаатар, Онгон сум/	2013	2014	616.9	54.9
XXV.1.39	Халдвартын эмнэлгийн барилга, 20 ор /Сэлэнгэ, Сүхбаатар сум/	2013	2014	1,060.5	110.5
XXV.1.40	Эрүүл мэндийн хөтөлбөр, эрүүл мэндийн ажилчдын орон сууц худалдан авах, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн шинэчлэл /Улаанбаатар/	2013	2014	360.9	52.5
XXV.1.41	Гэмтэл, согог судлалын үндэсний төвийн барилгын болон лифтийн засвар	2013	2014	301.4	101.4
	Шинэ			9,225.2	8,370.2
XXV.1.42	Сумын эрүүл мэндийн төв, 20 ор /Хөвсгөл, Их-Уул сум/	2014	2014	850.0	850.0
XXV.1.43	Сумын эрүүл мэндийн төв, 25 ор /Сэлэнгэ, Мандал сум/	2014	2014	2,080.2	2,080.2



XXV.1.44	Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн халдвартын эмнэлгийн барилга /Өвөрхангай, Арвайхээр сум/	2014	2014	1,900.0	1,900.0
XXV.1.45	Сумын эрүүл мэндийн төв, 10 ор /Баянхонгор, Шаргалжуут сум/	2014	2014	580.0	580.0
XXV.1.46	Сумын эрүүл мэндийн төв, 10 ор /Баянхонгор, Баянбулаг сум/	2014	2014	600.0	600.0
XXV.1.47	Сувиллын барилга, тоног төхөөрөмжийн шинэчлэл /Дорноговь, Эрдэнэ сум, "Бүрдэнэбулаг" бөөрний сувилал/	2014	2015	1,000.0	500.0
XXV.1.48	Хүүхдийн цусны төвийн барилгын үлдэгдэл санхүүжилт /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2014	2014	400.0	400.0
XXV.1.49	Эмнэлгийн барилга /Дорнод, Хэрлэн сум, 4 дүгээр баг/	2014	2015	705.0	350.0
XXV.1.50	Эхчүүдийн амрах байрны барилга /Увс, Сагил сум/	2014	2014	110.0	110.0
XXV.1.51	Өрхийн эмнэлгийн барилга /Говь-Алтай, Есөнбулаг сум, Энх-Алтай өрхийн эмнэлэг/	2014	2014	450.0	450.0
XXV.1.52	Эрүүл мэндийн төв /Хөвсгөл, Бүрэнтогтох сум/	2014	2014	550.0	550.0
XXV.2	II.Их засвар			13,777.6	13,660.9
	Шинэ			13,777.6	13,660.9
XXV.2.1	Харьяа газрын засвар	2014	2014	4,500.0	4,500.0
XXV.2.2	Нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын их засвар	2014	2014	3,000.0	3,000.0
XXV.2.3	Аймаг, сумын эмнэлгийн эрүүл мэндийн байгууллагуудын их засвар	2014	2014	5,200.0	5,200.0
XXV.2.4	Эмнэлгийн барилгын засвар /Баянхонгор/	2013	2014	148.7	32.0



XXV.2.5	Эмнэлгийн барилгын их засвар/Увс, Хяргас сум/	2014	2014	240.0	240.0
XXV.2.6	Халдварт өвчин судлалын үндэсний төвийн их засвар	2014	2014	688.9	688.9
XXV.3	III.Тоног төхөөрөмж			56,003.4	29,309.8
	Шилжих			44,345.1	18,151.5
XXV.3.1	Клиникийн II нэгдсэн эмнэлэг /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2013	2014	3,000.0	1,500.0
XXV.3.2	П.С.Шастины нэрэмжит клиникийн төв эмнэлэг /Улаанбаатар, Баянгол дүүрэг/	2013	2014	5,500.0	2,500.0
XXV.3.3	Хавдар судлалын үндэсний төвийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2013	2015	8,000.0	3,000.0
XXV.3.4	Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн шим тэжээл, хор судлал, биотехнологийн үндэсний үйлдвэрлэл /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2013	2014	2,000.0	1,000.0
XXV.3.5	Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/	2013	2015	7,702.9	1,851.5
XXV.3.6	Нийгмийн эрүүл мэндийн төвүүдийн тохижилт, тоног төхөөрөмж	2013	2014	4,000.0	1,500.0
XXV.3.7	Аймгийн нэгдсэн эмнэлгүүдэд шаардлагатай тоног төхөөрөмж	2013	2014	2,000.0	1,000.0
XXV.3.8	Эрүүл мэндийн байгууллагуудын түргэн тусламжийн автомашин	2013	2014	2,000.0	800.0
XXV.3.9	Зүрх, судасны тусламж үйлчилгээнд шаардагдах тоног төхөөрөмж	2013	2014	2,842.2	1,200.0



XXV.3.10	Гемодиализын тусламж үйлчилгээг клиникийн зарим эмнэлгүүд, аймгийн нэгдсэн эмнэлэг, дүүргийн нэгдсэн эмнэлгүүдэд шинээр байгуулах	2013	2014	1,500.0	800.0
XXV.3.11	Ариутгал, халдваргүйтгэл, цэвэрлэгээ, үйлчилгээний тусламж үйлчилгээг сайжруулах	2013	2014	3,500.0	1,500.0
XXV.3.12	Эмнэлгүүдийн яаралтай тусламж, эрчимт эмчилгээний тасгийг тохижуулах, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах	2013	2014	2,300.0	1,500.0
	Шинэ			11,658.3	11,158.3
XXV.3.13	Улсын нэгдүгээр төв эмнэлгийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2014	2014	1,000.0	1,000.0
XXV.3.14	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн хяналт тохиргооны төхөөрөмж /Улаанбаатар/	2014	2014	500.0	500.0
XXV.3.15	Удамзүйн лабораторийн тоног төхөөрөмж /Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг/	2014	2014	1,300.0	1,300.0
XXV.3.16	Оношлогооны төвийн тоног төхөөрөмж /аймгуудад/	2014	2014	3,214.3	3,214.3
XXV.3.17	Бүсийн оношлогоо, эмчилгээний төвийн тоног төхөөрөмж /Дорнод, Хэрлэн сум/	2014	2014	360.0	360.0
XXV.3.18	Аймгуудын Эрүүл мэндийн газрын түргэн тусламжийн автомашин, тоног төхөөрөмж, засвар /Дархан-Уул, сумдууд; Сэлэнгэ, Баянгол сум/	2014	2015	1,000.0	500.0
XXV.3.19	Дүүргийн эмнэлгүүдэд шаардлагатай тоног төхөөрөмж /Улаанбаатар/	2014	2014	2,300.0	2,300.0



XXV.3.20	Амаржих газруудад эх барихын яаралтай, нярайн нэн шаардлагатай тоног төхөөрөмж /аймаг/	2014	2014	1,200.0	1,200.0
XXV.3.21	Үргүйдлийн тусламж үйлчилгээг сайжруулах, эвсэл үр шилжүүлэн суулгах лабораторийн тоног төхөөрөмж /Улаанбаатар/	2014	2014	420.0	420.0
XXV.3.22	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ	2014	2014	364.0	364.0
XXVI	ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД			676,722.0	146,528.3
XXVI.1	I.Хөрөнгө оруулалт			676,162.0	146,268.3
	Цахилгаан дамжуулах сугам, дэд станц			296,833.4	69,863.6
	Шилжих			202,974.3	32,086.4
XXVI.1.1	Дундговь аймгийн Мандалговь-Өмнөговь аймгийн Тавантолгой-Оюутолгойн 2 хэлхээтэй 220 кВ-ын 429 км цахилгаан дамжуулах агаарын сугам, дэд станц /Өмнөговь/	2010	2014	160,000.0	15,000.0
XXVI.1.2	Эрдэнэт 220/110/35/6 кВ-ын дэд станцын хүчин чадлыг 2х200 МВА болгож нэмэгдүүлэх /Орхон/	2012	2014	6,923.9	2,443.9
XXVI.1.3	Улаанбаатар хотын гэр хорооллын өсөн нэмэгдэж байгаа хэрэглээг хангах, хэрэглэгчдийн цахилгаан хангамжийг сайжруулах /Улаанбаатар/	2013	2014	8,100.0	4,100.0
XXVI.1.4	Улаанбаатар хотын 87 км цахилгааны кабель сугамын өргөтгөл, шинэчлэлт /Улаанбаатар/	2013	2014	6,880.0	3,000.0



XXVI.1.5	Сумын 15 кВ-ын 61 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих /Баянхонгор, Шинэжинст, Баянцагаан сум/	2013	2014	1,800.0	1,000.0
XXVI.1.6	Хархорин, Мөрөн дэд станцад тус бүр 2 ком 6, 10 кВ-ын удирдлагатай реактор, Сайншанд дэд станцад 2 ком 35 кВ-ын синхрон компенсатор суурилуулах /Өвөрхангай, Хөвсгөл, Дорноговь/	2013	2014	720.0	720.0
XXVI.1.7	Цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц барих /Ховд, Жаргалант сум/	2013	2014	1,750.0	1,750.0
XXVI.1.8	35/10 кВ-ын Баянзүрх дэд станцын хүчин чадлыг 2х10 МВА болгож нэмэгдүүлэх /Улаанбаатар/	2012	2014	1,699.2	252.1
XXVI.1.9	Төвийн бүсийн эрчим хүчний системийн тоолуурын нэгдсэн системийн өргөтгөл /Улаанбаатар/	2013	2014	1,598.3	798.3
XXVI.1.10	Баруунтуруун сумын Хар-цагаан усны үтрэм, Булганхангай багийн цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц /Увс/	2012	2014	1,047.1	9.8
XXVI.1.11	Өндөр-Улаан сумын Хануй багийн 10 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц /Архангай/	2012	2014	596.6	91.0
XXVI.1.12	Дархан хотын 110/6 кВ-ын Давхар дэд станцын 110 кВ-ын ил, 6 кВ-ын хаалттай хуваарилах байгууламжийг шинэчлэх /Дархан-Уул/	2012	2014	2,381.1	102.2
XXVI.1.13	Тамсаг-Халх голын 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц /Дорнод/	2014	2015	4,450.0	2,658.5



XXVI.1.14	Чойбалсан 110/35/6 кВ-ын дэд станцыг 16 мВАх2 трансформатораар өргөтгөх /Дорнод/	2011	2014	1,929.9	96.5
XXVI.1.15	Оюутолгой-Баян-Овоо сум, Тавантолгой- Манлай сумын цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц /Өмнөговь/	2011	2014	2,759.8	28.1
XXVI.1.16	Бат-Өлзий сумын төвөөс Орхоны хүрхрээгээр дайрч Улаан амны баг хүртэлх 10 кВ-ын 30 км цахилгаан дамжуулах агаарын шугам /Өвөрхангай/	2012	2014	338.4	36.0
	Шинэ			93,859.1	37,777.2
XXVI.1.17	Умард дэд станцаас кабель шугам татаж 6 дугаар бичил хороололд шинээр 10 кВ-ын хуваарилах байгууламж барих /Улаанбаатар/	2014	2015	2,523.1	1,000.0
XXVI.1.18	1 дүгээр хорооллын ХТП5-ын дэргэд 10 кВ-ын хуваарилах байгууламж шинээр барих /Улаанбаатар/	2014	2015	1,015.5	515.5
XXVI.1.19	Амгалан дэд станцаас кабель шугам татаж ХТП208-ын дэргэд шинээр 10 кВ-ын хуваарилах байгууламж барих /Улаанбаатар/	2014	2015	1,000.6	500.0
XXVI.1.20	35/6 кВ-ын Баянхошуу 2х10 МВА чадалтай шинэ дэд станц барьж, 35 кВ-ын 7.2 км 2 хэлхээ ЦДАШ татах /Улаанбаатар/	2014	2015	2,021.1	800.0
XXVI.1.21	35/10 кВ-ын Дашчойнхор 2х6.3 МВА чадалтай шинэ дэд станц барих /Улаанбаатар/	2014	2015	1,897.0	897.0



XXVI.1.22	Гэр хорооллын хүчдэлийн уналттай болон шинэ суурьшлын бүсийн гэр хорооллын айл өрхийг цахилгаан хангамжаар хангах /Улаанбаатар/	2014	2015	9,000.0	2,500.0
XXVI.1.23	Улаанбаатар хотын төвийн 6, 10 кВ-ын кабель шугамын шинэчлэлт /Улаанбаатар/	2014	2015	6,000.0	2,250.9
XXVI.1.24	Үйлдвэрийн районы 35 кВ-ын 35/6 кВ-ын 2х6300 кВА дэд станц, 35кВ-ын хуурай салгуурын пунктын өргөтгөл /Дархан-Уул/	2014	2015	4,097.2	2,000.0
XXVI.1.25	Хөтөл хорооны 6 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 6/0.4 кВ-ын дэд станц, 0.4 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам татах /Дархан-Уул, Дархан сум, Хөтөл хороо/	2014	2015	1,822.4	822.4
XXVI.1.26	Байдлаг дэд станцыг 35/10кВ-ын дэд станц болгон өргөтгөх, 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам татах /Улаанбаатар, Багануур дүүрэг/	2014	2015	1,499.7	799.7
XXVI.1.27	Залаат, Бага тэнгэр, Их тэнгэрийн ам, Хан-Уул, Баянзүрх дүүргийн хорооллуудын цахилгаан хангамжийг сайжруулах зорилгоор 110/10 кВ-ын дэд станц, 110 кВ-ын 7,6 км цахилгаан дамжуулах агаарын шугам /Улаанбаатар/	2014	2015	9,000.0	4,500.0
XXVI.1.28	Завхан сумаас Хэцүү хад хүртэлх цахилгаан дамжуулах агаарын шугам, 15/0,4 кВ-ын дэд станц /Увс, Завхан сум/	2014	2014	847.0	847.0



XXVI.1.29	Айраг-Даланжаргалан 35 кВ-ын 25.2 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц /Дорноговь/	2014	2015	1,290.0	690.0
XXVI.1.30	Баруун-Урт-Талбулагийн 10 кВ-ын 34.9 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц /Сүхбаатар/	2014	2014	477.7	477.7
XXVI.1.31	Төв аймгийн шинэ суурьшлын бүсийн хэрэглэгчдийн цахилгаан хангамжийг сайжруулах /Төв/	2014	2015	3,940.0	1,817.0
XXVI.1.32	Баруун-Урт-Эрдэнэцагааны 35 кВ-ын 197 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц, 110/35/6 кВ-ын дэд станцын өргөтгөл /Сүхбаатар/	2014	2015	8,900.0	3,000.0
XXVI.1.33	Багуудын цахилгаан хангамжийг сайжруулах /Дорнод, Хэрлэн сум, 1,8 дугаар баг/	2014	2014	700.0	700.0
XXVI.1.34	"Булган хангай" хорооллыг дулаан, цахилгаан эрчим хүчээр хангах /Архангай, Эрдэнэбулган сум/	2014	2014	1,800.0	1,800.0
XXVI.1.35	Цахилгаан дамжуулах агаарын шугам /Увс, Цагаанхайрхан сум, Хунт, Хулж баг/	2014	2014	360.0	360.0
XXVI.1.36	35 кВ-ын 25 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц /Баян-Өлгий, Сагсай, Улаанхус сум/	2014	2015	2,000.0	1,000.0
XXVI.1.37	10/0.4 кВ-ын 24.3 км цахилгаан дамжуулах агаарын шугам, дэд станц /Дорноговь, Эрдэнэ сум, "Бүрдэнэбулаг" бөөрний сувилал/	2014	2015	1,000.0	500.0



XXVI.1.38	Хорооллын гадны цахилгаан хангамж 6/0,4 кВ-ын 2х630 кВа ХТП-15 ком, 6 кВ-ын 34,9 км кабель шугам /Дархан-Уул, Дархан сум, 11, 12, 24, 25, 26 дугаар хороолол/	2014	2016	10,217.2	3,500.0
XXVI.1.39	Хорооллын гадны цахилгаан хангамж 6/0,4 кВ-ын 2х630 кВа ХТП-8 ком, 6 кВ-ын 10,5 км кабель шугам /Дархан-Уул, Дархан сум, 2,3 дугаар хороолол/	2014	2016	5,450.6	1,500.0
XXVI.1.40	Томоохон баг, суурин газруудыг эрчим хүчээр хангах, сумдын 0.4 кВ-ын шугамын өргөтгөл, шинэчлэлт	2014	2016	17,000.0	5,000.0
	Дулааны цахилгаан станц, дулааны шугам			363,913.6	73,395.7
	Шилжих			95,968.5	34,175.7
XXVI.1.41	Дулааны сүлжээний өргөтгөл /Хөвсгөл, Мөрөн сум, Төв зах, Гурван Эрдэнэ сургууль, Зүүн талын шинэ хороолол/	2012	2014	5,000.0	3,500.0
XXVI.1.42	Дулааны станц, шугам сүлжээ /Ховд, Жаргалант сум/	2011	2014	16,000.0	9,602.0
XXVI.1.43	Дулааны станцын КВТС-10/150 зуух барих /Улаанбаатар, Налайх дүүрэг/	2013	2014	2,981.0	1,481.0
XXVI.1.44	Дулааны цахилгаан станц 2-ын цахилгаан тоноглолын шинэчлэл /Улаанбаатар/	2013	2014	2,194.5	1,194.5
XXVI.1.45	Дулааны шугам сүлжээг өргөтгөх, шинэчлэх /Сэлэнгэ, Сүхбаатар/	2013	2014	1,492.6	742.6
XXVI.1.46	Шинээр баригдах орон сууцны 11,12,13 дугаар хороолол руу дулааны шугам шинээр тавих, хуучин шугамыг өргөтгөх /Дархан-Уул, Дархан сум/	2013	2014	1,711.4	811.4



XXVI.1.47	Дулааны станцын дулаан хангамжийн нэгдсэн системийг үл хамаарах схемд шилжүүлэх, үндсэн магистрал шугам сүлжээг шинэчлэх /Улаанбаатар, Багануур дүүрэг/	2013	2014	3,538.3	1,138.3
XXVI.1.48	бд магистралийн Тк-639-өөс Тк-643 хүртэлх 1223 метр шугамыг өргөтгөх /Улаанбаатар/	2013	2014	2,548.5	1,298.5
XXVI.1.49	2 г, д магистралийн Тк-226-аас Тк-234 хүртэлх 1400 метр шугамыг өргөтгөх /Улаанбаатар/	2013	2014	1,531.5	531.5
XXVI.1.50	Төвлөрсөн дулаан хангамжийн шугамын шинэчлэл /Хөвсгөл, Мөрөн сум/	2013	2014	15,931.3	11,931.3
XXVI.1.51	Дулааны шугам сүлжээний шинэчлэл /Сүхбаатар, Баруун-Урт сум/	2010	2014	13,000.0	7.8
XXVI.1.52	Дулааны станц барих /Хөвсгөл/	2010	2014	7,966.3	583.6
XXVI.1.53	Дулааны шугам сүлжээний шинэчлэл /Хөвсгөл/	2010	2014	5,956.3	271.6
XXVI.1.54	Дулааны станц барих /Увс, Улаангом сум/	2011	2014	7,435.0	962.7
XXVI.1.55	Дулааны шугам сүлжээний шинэчлэл /Увс/	2011	2014	4,919.2	9.7
XXVI.1.56	ДЦС-2-оос Тк-844 хүртэлх Ф350 мм, Ф400 мм голчтой 2130 хос м шугамыг Ф700, Ф600 мм голчтой болгон өргөтгөн шинэчлэх /Улаанбаатар/	2011	2014	1,835.8	32.8
XXVI.1.57	Дулааны 3Д магистрал шугамын шинэчлэл /Улаанбаатар, Хан-Уул дүүрэг/	2012	2014	1,438.0	34.2
XXVI.1.58	Дулааны станц, дулааны шугам сүлжээний шинэчлэлийн техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах /Завхан/	2012	2014	488.8	42.2



	Шинэ			267,945.2	39,220.0
XXVI.1.59	5В магистраль Тк-1893-с Континенталь зочид буудлын баруун талын уулзвар хүртэлх 2100 метр 2х500 мм-ийн шугамыг 2х800 мм болгон өргөтгөх /Улаанбаатар/	2014	2015	5,820.0	2,520.0
XXVI.1.60	1в магистралйн Тк-1893-с Тк-117 цэг хүртэлх 1500 метр 2х500 мм-ийн шугамыг 2х700 мм шугам болгон өргөтгөх /Улаанбаатар/	2014	2015	3,252.3	1,500.0
XXVI.1.61	Дарханы дулааны цахилгаан станцад хаягдал үнсэн сан шинээр барих /Дархан-Уул/	2014	2015	8,500.9	3,000.0
XXVI.1.62	Багануурын дулааны станцын сүлжээний усны зарцуулалт хувьсах насосны горимд шилжих /Улаанбаатар, Багануур дүүрэг/	2014	2015	3,372.0	1,500.0
XXVI.1.63	Дулааны цахилгаан станц 2-ын Р-4 /АК-6/ турбины шинэчлэлийн ажил /Улаанбаатар/	2014	2015	3,000.0	1,500.0
XXVI.1.64	Аймгийн төвүүдэд шинээр дулааны станц, дулааны шугам барих /Баянхонгор, Завхан, Өвөрхангай, Төв, Архангай, Говь-Алтай, Дундговь, Хэнтий, Булган/	2014	2016	160,000.0	24,000.0
XXVI.1.65	Сумдын төвлөрсөн дулаан хангамж	2014	2016	84,000.0	5,200.0
	Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах			10,415.0	2,009.0
XXVI.1.66	"ДЦС-4"ТӨХК-ийн уур, усны дулаан солилцуулагч бүхий дулааны дэд станц /Улаанбаатар/	2012	2014	10,415.0	2,009.0
	Гадаадын зээлээр хэрэгжих дотоод эх үүсвэр			5,000.0	1,000.0



XXVI.1.67	Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх Дарханы дулааны цахилгаан станцын техникийн шинэчлэлийн монголын талын хөрөнгө /Дархан-Уул, Дархан сум/	2009	2014	5,000.0	1,000.0
	Эрчим хүчний яам			560.0	260.0
XXVI.3	III.Тоног төхөөрөмж			560.0	260.0
	Шилжих			560.0	260.0
XXVI.3.1	Дулааны цахилгаан станц, станцын горим, үндсэн ба туслах тоноглолын ашиглалтын лабораторийг шинээр байгуулах /Улаанбаатар/	2013	2014	560.0	260.0
	НИЙТ ДҮН			2,887,096.9	1,135,879.1

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 05 дугаар сарын 23-ны өдөр

Улаанбаатар хот

НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2014 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсгийн “Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд 1,247,206.4” гэснийг “Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайд 1,249,512.0” гэж, 3.1.1.3 дахь дэд заалтын “Төсөвт байгууллагаас төлөх шимтгэл 149,211.7” гэснийг “Төсөвт байгууллагаас төлөх шимтгэл 151,517.4” гэж, 3 дугаар зүйлийн “Нийт орлого 1,567,337.7” гэснийг “Нийт орлого 1,569,643.3” гэж, 4 дүгээр зүйлийн 4.1.1.7 дахь дэд заалтын “Үйл ажиллагааны урсгал зардал 20,166.9” гэснийг “Үйл ажиллагааны урсгал зардал 20,041.4” гэж, 4 дүгээр зүйлийн “Нийт зарлага 1,289,289.2” гэснийг “Нийт зарлага 1,289,163.8” гэж тус тус өөрчилсүгэй.

2 дугаар зүйл.Нийгмийн даатгалын сангийн 2014 оны төсвийн тухай хуулийн хавсралтаар баталсан “Нийгмийн даатгалын сангийн хөрөнгөөр 2014 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга



хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт"-ын төсөл арга хэмжээний нэр байршлын 1.8 дахь заалтыг “Нийгмийн даатгалын үйлчилгээний барилга /Улаанбаатар, Баянзүрх дүүрэг/” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2014 оны 05 дугаар сарын 23-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 05 дугаар
сарын 23-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд 2014 оны 02 дугаар сарын 06-ны өдөр байгуулсан “Хүнс, тэжээл, нийгмийн халамжийн төсөл: Нэмэлт санхүүжилт”-ийн зээлийн хэлэлцээрийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 05 дугаар
сарын 23-ны өдөр

Улаанбаатар
хот

САНХҮҮЖИЛТИЙН ЕРӨНХИЙ ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд 2013 оны 12 дугаар сарын 09-ний өдөр байгуулсан “Гэр хорооллыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг дэмжих хөтөлбөр”-ийн санхүүжилтийн ерөнхий хэлэлцээрийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2014 оны 05 дугаар
сарын 23-ны өдөр

Улаанбаатар
хот

ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар, Японы Олон улсын хамтын ажиллагааны байгууллага хооронд 2014 оны 03 дугаар сарын 12-ны өдөр байгуулсан “Инженер, технологийн дээд боловсрол” төслийн зээлийн хэлэлцээрийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны 05 дугаар
сарын 15-ны өдөр

Дугаар 36

Улаанбаатар
хот

Хяналтын тухай хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3.7 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газраас 2014 оны 4 дүгээр сарын 01-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хяналтын тухай хуулийн төсөл болон түүнтэй хамт өргөн мэдүүлсэн холбогдох бусад хуулийн төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хэлэлцэх шаардлагагүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2014 оны 05 дугаар
сарын 15-ны өдөр

Дугаар 37

Улаанбаатар
хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:



1.Монгол Улсын Засгийн газраас 2013 оны 06 дугаар сарын 25-ны өдөр өргөн мэдүүлсэн Газрын тосны тухай хууль /Шинэчилсэн найруулга/, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Улсын нөөцийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Татварын ерөнхий хуульд нэмэлт оруулах тухай, Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Газрын тосны тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай, Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслүүдийг батлах саналыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

З.ЭНХБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2014 оны 05 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 62

Улаанбаатар
хот

Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Авлигын эсрэг хуулийн 27 дугаар зүйлийн 27.2, 27.5 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Нэг. Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор баталсугай.

Хоёр. Энэ зарлиг гарсантай холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2009 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 121 дүгээр зарлигийг хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ



Монгол Улсын Ерөнхийлөгчийн
2014 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн
62 дугаар зарлигийн хавсралт

Авлигатай тэмцэх газрын дэргэдэх Олон нийтийн
зөвлөлийн бүрэлдэхүүн

д/д	Овог, нэр	Байгууллага
1.	Т.Хасбаатар	Үндэсний байгаль орчны хамтын ажиллагааны нийгэмлэг
2.	П.Эрдэнэжаргал	Нээлттэй нийгэм форум
3.	Н.Дорждарь	Орлогын ажиглагч хүрээлэн
4.	Л.Төр-Од	Транспаренси Интэрнейшнл Монгол
5.	М.Мөнхбат	МУИС-ийн Хууль зүйн сургууль
6.	Д.Цэрэнжав	Ил тод байдал сан
7.	Л.Сумати	Сант марал сан
8.	Х.Наранжаргал	Глоб Интэрнейшнл
9.	Б.Амар	Зориг сан
10.	Н.Урантогтох	Пи Ар боловсрол олгох төв
11.	М.Оюунчимэг	Үндэсний худалдаа аж үйлдвэрийн танхим
12.	Р.Батсайхан	Нирум фильм студи
13.	М.Уламбадрах	Эн Ти Ви суваг
14.	Б.Нямдорж	Өдрийн мэдээ ХХК
15.	С.Насанжаргал	25 дугаар суваг

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2014 оны 05 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 63

Улаанбаатар
хот

**Шүүхийн Ёс зүйн хорооны гишүүнийг
чөлөөлөх тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүхийн захиргааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.4-г тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Өөрөө хүсэлт гаргасан тул Төмөрбаатарын Бат-Өлзийг Шүүхийн Ёс зүйн хорооны гишүүний үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ**

2014 оны 05 дугаар
сарын 26-ны өдөр

Дугаар 64

Улаанбаатар
хот

**Шүүхийн Ёс зүйн хорооны гишүүнийг
томилох тухай**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 1, Шүүхийн захиргааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3, 32.4-г тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Одонхүүгийн Мөнхсайхан, Балдангийн Уранцэцэг нарыг Шүүхийн Ёс зүйн хорооны гишүүнээр тус тус томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2014 оны 3 дугаар
сарын 28-ны өдөр

Дугаар 105

Улаанбаатар
хот

**Нээлттэй боловсролын “Нэг Монгол”
үндэсний хөтөлбөр батлах тухай**

Засгийн газрын тухай хуулийн 30.1 дэх хэсгийг үндэслэн, Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нээлттэй боловсролын “Нэг Монгол” үндэсний хөтөлбөрийг хавсралт ёсоор баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Гантөмөрт даалгасугай:

1) хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны дунд, урт хугацааны стратеги болон жил бүрийн төлөвлөгөөг батлан хэрэгжүүлэх;

2) хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг хуульд заасан журмын дагуу сонгон шалгаруулж, гэрээ байгуулан ажиллах;

3) хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалтыг улсын хэмжээнд хангаж, хэрэгжилтийн явцад хяналт, шинжилгээ хийж, тайланг хоёр жил тутам Засгийн газарт танилцуулах.



3. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан “Жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2013 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 408 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр Худалдан авах ажиллагааны газрын 2014 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ын “XVII.1.3.4 Нээлттэй боловсрол төсөл (Улаанбаатар)” гэснийг хассугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

Н.АЛТАНХУЯГ

**БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ
УХААНЫ САЙД**

Л.ГАНТӨМӨР

Засгийн газрын 2014 оны 105 дугаар
тогтоолын хавсралт

**НЭЭЛТТЭЙ БОЛОВСРОЛЫН “НЭГ МОНГОЛ”
ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР**

Нэг. Нийтлэг үндэслэл

Улсын Их Хурлын 2008 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”-ын баримт бичигт “Бүх нийтийн боловсролыг нийгмийн үйл хэрэг болгон хөгжүүлж, үндэсний боловсролын тогтолцоог олон улсын түвшинд ойртуулан төгөлдөржүүлж, оюунжсан, бүтээлч, чадамжтай хүний нөөцийг байнга нэмэгдүүлнэ. Иргэд боловсролоо сайжруулж, ажил мэргэжлээрээ хөрвөн суралцаж байх бодит боломж олгосон боловсролын нээлттэй агуулга, уян хатан арга хэлбэрийг бий болгож хэрэгжүүлнэ” гэсэн зорилтуудыг дэвшүүлсэн.

Улсын Их Хурлаас баталсан Засгийн газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт “... эх оронч сэтгэлгээтэй, амьдрах ухаанд суралцсан иргэн төлөвшүүлэхэд чиглэсэн “Зөв монгол хүүхэд” хөтөлбөр, “Өрсөлдөх чадвартай монгол хүн” хөтөлбөр хэрэгжүүлнэ.” гэж тус тус заасан.

Үндэсний уламжлал, хөгжил болон даяаршлаас үүдэлтэй соёл, нийгмийн харилцааны өөрчлөлтийн зааг дээр монгол хүн бүрийн хөгжил, төлөвшлийн талаарх бодлого, холбогдох арга хэмжээг оновчтой тодорхойлж, улс орны хөгжлийн төлөөх эрх ашигт нийцүүлэн хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага бий болж байна.



Өнөөгийн боловсролын салбарыг хөдөлмөрийн зах зээлээ дэмжих чадвар сул, ажиллах хүн хүчний нөөцийг бүрэн бүрдүүлэх чадамжгүй, суралцагчдын иргэний төлөвшлийг хангалттай түвшинд хүргэж чаддаггүй гэж дүгнэсээр байгаа юм.

Даяаршил, шинжлэх ухаан, технологийн дэвшлийн эрин үе нь нээлттэй, өрсөлдөөнтэй, мэдээлэлжсэн орчинд амьдрах чадварыг хүн бүрээс шаардаж байгаагаас дэлхийн улс орнууд боловсролын бодлогоо шинэ зуунд хүн төрөлхтөний нийтлэг асуудлыг шийдвэрлэхэд оролцох мэдлэг чадвартай, бүтээлч, хариуцлагатай, насан туршдаа суралцах чадвартай иргэн төлөвшүүлэхэд чиглүүлж байна.

Хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгэм байгуулах эрхэм зорилгын хүрээнд гэр бүлийн сайн сайхан байдал, иргэн нэг бүрийн хөгжлийг хангахад чиглэсэн төрийн бодлогын үндсийг шинээр дэвшүүлэн тавьж, мэдээлэл, холбооны технологид суурилсан, нээлттэй, насан туршийн, тасралтгүй, чанартай боловсрол эзэмших боломжийг бий болгох нь нээлттэй боловсролын “Нэг Монгол” үндэсний хөтөлбөрийг боловсруулах нийтлэг үндэслэл болно.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго

Иргэн бүр авьяас, чадвараа хөгжүүлэх, үр бүтээлтэй хөдөлмөрлөж, аз жаргалтай амьдрах, ёс суртахуун, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахиж, үндэсний нийтлэг үнэт зүйлсийг өвлөн насан туршдаа суралцах хэрэгцээнд нь нийцсэн нээлттэй боловсролын үндэсний шинэ тогтолцоог бий болгоно.

Гурав. Хэрэгжүүлэх төсөл, үйл ажиллагаа

Нээлттэй боловсролын “Нэг Монгол” үндэсний хөтөлбөрийн хүрээнд дараах төслүүдийг хэрэгжүүлнэ:

3.1. “Нээлттэй академи” төсөл

Хүүхдийн итгэл, найдвар, сурах тэмүүллийг нь дэмжиж, сургалтыг суралцагч өөрийн үйл явцад суралцдаг арга зүйд суурилсан “ерөнхий боловсролын сургуулийн сурагч, багш нарт зориулсан үнэ төлбөргүй, нээлттэй онлайн боловсролын үйлчилгээ”-г боловсролын тогтолцоонд нэвтрүүлэх төслийг хэрэгжүүлнэ. Энэ төслийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:



3.1.1. дэлхий даяар хамгийн өндөр хандалт, ашиглалттай, үнэ төлбөргүй, онлайн, нээлттэй сургалтын үйлчилгээ болох АНУ-ын Хан Академийн ерөнхий боловсролын сургуулийн сургалтын математик, физик, хими, биологи, анатоми, байгаль ба нийгмийн ухаан, мэдээллийн технологи, эдийн засаг, түүхийн хичээл, мөн АНУ-ын их, дээд сургуулийн SAT, GMAT элсэлтийн шалгалтын онлайн видео хичээлийг бүрэн орчуулж, ерөнхий боловсролын сургуулийн багш, сурагчдад нээлттэй, үнэ төлбөргүй ашиглах боломжийг бий болгоно;

3.1.2. ерөнхий боловсролын сургуулийн сурагч, багшийн сургалтын видео хичээлийн сан, нээлттэй сургалтын онлайн системийг бий болгоно;

3.1.3. ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын сурах бичиг, багшийн ном, сургалтын гарын авлагуудыг цахим хэлбэрт шилжүүлж, цахим сурах бичиг, багшийн ном, гарын авлагуудыг бүтээж, хэрэглээнд нэвтрүүлнэ;

3.1.4. ерөнхий боловсролын сургуулийн 6-12 дугаар ангийн байгалийн ухааны болон математикийн хичээлийн онлайн виртуал лабораторийг хөгжүүлж сургалтад нэвтрүүлнэ;

3.1.5 ерөнхий боловсролын сургуулиудыг мэдээлэл, холбооны өндөр технологид суурилсан ухаалаг (smart school) сургууль болгох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ;

3.1.6. Гүүгэл (Google) корпорацийн дэмжлэгтэйгээр ерөнхий боловсролын нийт сургууль болон багш сурагчдыг дэлхийд хамгийн өргөн ашиглагддаг, үнэ төлбөргүй, нээлттэй сургалтын багц үйлчилгээтэй болгоно;

3.1.7. ерөнхий боловсролын сургуулийн сурагч, багш нарт зориулсан компьютер, таблет, гар утас зэрэг бүх төрлийн мэдээлэл, холбооны хэрэгслийн орчинд хэрэглэгдэх сургалтын программ хангамжийг хөгжүүлнэ.

3.2. “Монгол хэл” төсөл

Монгол Улс үндэстэн оршихуйн үндэс болсон эх хэл, соёл, сэтгэлгээний үндэсний дархлааг бэхжүүлэх, бүх түвшний боловсрол, сургалтын чанар, иргэдийн харилцааны соёлын түвшинг дээшлүүлэх



зорилгоор бүх нийтийн монгол кирилл бичгийн нээлттэй сургалтын орчинг бий болгох “Монгол хэл” төслийг хэрэгжүүлнэ. Энэ төслийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

3.2.1. монгол хэл бичгийн нийтээр дагаж мөрдөх кирилл, уйгаржин бичгийн онлайн тайлбар толь бичгийг бүтээнэ;

3.2.2. монгол хэлийг эхлэн суралцагчийн түвшнээс эхлээд гүнзгий, ахисан түвшний онлайн сургалт, үндэсний шалгалтын системийг боловсруулж, бүх түвшний сургалт, хэрэглээнд нэвтрүүлнэ;

3.2.3. монгол кирилл бичгийн үсгийн дүрмийн алдаа засах компьютерийн программ хангамжийг зохиож, бүх нийтийн хэрэглээнд нийлүүлнэ.

3.3. “Нээлттэй их сургууль” төсөл

Хэн ч, хаанаас ч хүссэн цагтаа хэрэгтэй бүх мэдээллээ орон зай, цаг хугацааны хязгаарлалтгүйгээр хүлээн авч өөрийн боломжоороо бүтээлчээр судлах, профессор багшаас оюутнуудтайгаа онлайнгаар хамтран бүтээж суралцах нээлттэй боломжийг дээд боловсролын тогтолцоонд бий болгох зорилгоор үүлэн технологи бүхий нээлттэй их сургуулийг хөгжүүлэх “Нээлттэй их сургууль” төслийг хэрэгжүүлнэ. Энэ төслийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ:

3.3.1. үндэсний эдийн засаг, хөдөлмөрийн зах зээлд өндөр эрэлттэй их, дээд сургуулийн хөтөлбөрүүдийг хөгжингүй орнуудын дэлхийн шилдэг их сургуулиудын түвшинд боловсруулж цахим, видео, виртуал хэлбэрт шилжүүлэн нээлттэй хэлбэрээр суралцах боломжийг бий болгоно;

3.3.2. дэлхийн шилдэг их сургуулиудаас сургалтад шууд хэрэглэх боломжтой, өндөр эрэлттэй мэргэжлийн сургалтын агуулга, хөтөлбөр, хичээл, лекцийг цахим, видео, виртуал хэрэглэгдэхүүний хамт эзэмших эрхийг нь худалдан авч их сургуулийн сургалтад нэвтрүүлнэ;

3.3.3. Гүүгэл (Google) корпорацийн дэмжлэгтэйгээр бүх их, дээд сургууль, коллежийн оюутан, багш нарыг дэлхийд хамгийн өргөн ашиглагддаг, үнэ төлбөргүй, нээлттэй сургалтын багц үйлчилгээтэй болгоно;



3.3.4. иргэд авьяас, хүсэл, хэрэгцээ, сонирхолдоо нийцүүлэн мэргэжил, ур чадвараа тасралтгүй хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилго бүхий насан туршийн боловсролын нээлттэй их сургуулийг хөгжүүлнэ.

3.4. “Үнэн түүх” төсөл

Монголчуудын угсаа, гарвал, үнэн бодит түүхийг үр хүүхэд, залуучууд, нийт иргэд, дэлхий нийтэд мэдүүлж таниулах, үндэсний бахархал, ухамсар, үнэт зүйлсийг хөгжүүлэн бэхжүүлэх “Үнэн түүх” төслийг хэрэгжүүлнэ. Төслийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

3.4.1. түүхчид, эрдэмтэд, хэвлэл, мэдээлэл, олон нийтийн өргөн оролцоотойгоор монголын түүхийн эх сурвалж, баримт бичиг, түүх, баримтуудыг цахим хэлбэрт шилжүүлж түүхэн эх сурвалжийн нээлттэй санг бий болгоно;

3.4.2. иргэд, олон нийтэд зориулсан монголын түүх, соёлын тухай танин мэдэхүйн болон баримтат, уран сайхны нийтлэл, нэвтрүүлэг, кино зэрэг уран бүтээлийг шинээр хийх, хуучныг нь сэргээн засварлах байдлаар нээлттэй мэдээлийн санг бий болгож олон нийтийн хүртээл болгоно;

3.4.3. олон улсын бусад нээлттэй сайтад Монгол Улсын нийгэм, эдийн засгийн талаарх нийтлэл, мэдээллийг өргөжүүлнэ.

3.5. “Үндэсний соёл” төсөл

Хүүхэд, залуучууддаа үндэсний соёл, уламжлал, ёс заншлыг өвлүүлэн эзэмшүүлж уламжлан хөгжүүлэх, монгол үндэстний ахуй, соёл болон өнөөгийн Монгол Улсын нийгэм, эдийн засгийг дэлхий нийтэд таниулан сурталчлахад чиглэсэн “Үндэсний соёл” төслийг хэрэгжүүлнэ. Энэ төслийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

3.5.1. ерөнхий боловсролын сургуулийн сурагчид болон бүх нийтэд зориулсан дэлхийн болон монголын утга зохиолын шилдэг бүтээл, зан заншил, түүх, соёлын биет болон биет бус үнэт өвийг танилцуулах цахим, видео, виртуал, нээлттэй мэдээллийн санг байгуулна;

3.5.2. монголын тухай аудио, видео, цахим, виртуал, нээлттэй агуулга бүхий Монголпедиа нэвтэрхий толийг бүтээнэ;



3.5.3. виртуал галлерей, музей байгуулах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

3.6. “Нээлттэй мэдлэг” төсөл

Нээлттэй мэдлэгийн үндэсний нэгдмэл санг бий болгох, шинжлэх ухаан, үйлдвэрлэл, бизнесийн ноу хауг хөгжүүлэх, мэдлэг, бизнес-инноваци, технологийг бүтээх, хөгжүүлэхэд нь дэмжлэг үзүүлэх, шинжлэх ухаан, өндөр технологид суурилсан өрсөлдөх чадамжтай үндэсний эдийн засаг, үйлдвэрлэлийн хөгжлийг эрчимжүүлэхэд чиглэсэн “Нээлттэй мэдлэг” төслийг хэрэгжүүлнэ. Энэ төслийн хүрээнд дараах ажлуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

3.6.1. эрдмийн бүтээл, докторын ажил, дипломын ажлын үндэсний нээлттэй санг байгуулна;

3.6.2. дэлхийн шинжлэх ухааныг монголын эрдэмтэн, судлаачдад нээж, Томсон Ройтерс (Thomson Reuters) корпорацийн “Web of science”, “Web of knowledge”, “Community of science” болон Скопус (Scopus), Шпрингер (Springer)-ийн шинжлэх ухааны мэдээллийн санд их сургууль, эрдэм шинжилгээний хүрээлэн, эрдэмтэн, судлаачдыг чөлөөтэй нэвтрэн ажиллах боломжийг бүрдүүлнэ.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх нөхцөл

Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах нөхцөлийг бүрдүүлнэ. Үүнд:

4.1. Насан туршийн боловсролын үндэсний тогтолцоог бүрдүүлэн хөгжүүлэх талаар хууль, эрх зүйн таатай орчинг бий болгон, санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх;

4.2. Бүх нийтийн буюу оюуны өмчийн олон улсын эрх зүйн тогтолцоонд Монгол Улс нэгдэн орох, түүний харилцаа, зохицуулалтыг бий болгох, интернэтэд зохиогчийн эрхийг хамгаалах, зохицуулах эрх зүйн орчныг бий болгох;

4.3. Боловсролын салбарын интернэт сүлжээний ерөнхий холболтын загвар (топологи) болон өгөгдлийн (дата) төвийн хүчин чадлыг тодорхойлж, нэгдсэн сүлжээгээр хангах, боловсролын салбарын удирдлага мэдээллийн системийг 2016 он гэхэд бүрэн хэмжээгээр байгуулж, хэрэгжүүлэх.



Тав. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт

5.1. Боловсрол, шинжлэх ухааны яам нээлттэй боловсролын “Нэг Монгол” үндэсний хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалтыг улсын хэмжээнд хариуцан гүйцэтгэнэ.

5.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд Шадар сайдын ажлын алба, Соёл, спорт, аялал, жуулчлалын яам, Мэдээллийн технологи, шуудан, харилцаа, холбооны газар хамтран оролцоно.

5.3. Боловсрол, шинжлэх ухааны сайд нь хөтөлбөр, түүнийг санаачлагч “Шинэ бодлогын хүрээлэн”(ТББ), “Нээлттэй мэдлэг, боловсролын сан”(ТББ)-гийн мэргэжлийн төслийн багтай хөтөлбөрийг хэрэгжүүлэх менежментийн гэрээ байгуулан ажиллана.

5.4. Боловсрол, шинжлэх ухааны яам нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх урт, дунд хугацааны стратеги төлөвлөлт, үйл ажиллагааны жил бүрийн төлөвлөгөөг гарган Засгийн газрын хуралдаанд танилцуулна.

5.5. Боловсрол, шинжлэх ухааны яам хөтөлбөрийн явцад хяналт, шинжилгээ хийж, тайланг хоёр жил тутам Засгийн газрын хуралдаанд болон иргэд, олон нийтэд нээлттэйгээр танилцуулна.

5.6. Хөтөлбөрийг төр, хувийн хэвшил, хэвлэл мэдээлэл, иргэд, олон нийтийн нээлттэй оролцоо, хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлнэ.

Зургаа. Хөтөлбөрийн санхүүжилт

6.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө нь улсын төвлөрсөн төсөв болон орон нутгийн төсөв, гадаад улс орон, олон улсын хөгжлийн байгууллага, хувийн хэвшлийн хандив, тусламж, хөгжлийн зээлийн эх үүсвэрээс бүрдэнэ.

6.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах улсын төсвийн хөрөнгийн эх үүсвэрийг эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, жил бүрийн улсын төвлөрсөн төсөв болон орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлнэ.

Долоо. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

7.1. Хөтөлбөрийг 2014-2024 онд хэрэгжүүлнэ.



7.2. Хөтөлбөрийн урт, дунд хугацааны стратеги, үйл ажиллагааны жил бүрийн төлөвлөлтийн хэрэгжилтийн тайлагналыг энэхүү хөтөлбөрийн 5 дугаар бүлгийн 5.3, 5.4, 5.5-д заасны дагуу зохион байгуулна.

Найм. Хөтөлбөрийн хэрэгжилт, хүрэх үр дүн

8.1. “Нээлттэй академи” төсөл:

8.1.1. Ерөнхий боловсролын сургуулийн математик, байгалийн ухаан, мэдээллийн технологи, нийгмийн ухаан, эдийн засаг, түүхийн хичээлийг орчуулж, 1-12 дугаар анги тус бүрт зориулж видео хэлбэрээр нээлттэй ашиглах боломж бүрдүүлнэ. 2014 онд 1000, 2015 онд 2000, 2016 онд 2000 видео хичээлийг орчуулж нийтийн хүртээл болгоно;

8.1.2. ерөнхий боловсролын сургуулийн сурагч, багшийн сургалтын видео хичээлийн сан, онлайн нээлттэй сургалтын систем бий болно. 2017 оноос жил бүр 200 видео хичээлийг бэлтгэнэ;

8.1.3. ерөнхий боловсролын сургуулийн математик, физик, хими, биологи, байгалийн ухааны онлайн виртуал лабораторийг хөгжүүлж ерөнхий боловсролын сургалтад нэвтрүүлнэ. 2018 оноос жил бүр 1 онлайн лабораторийн үйлчилгээг багш, сурагчдын хүртээл болгоно;

8.1.4 ерөнхий боловсролын сургуулиудыг мэдээлэл, холбооны өндөр технологид суурилсан ухаалаг (smart school) сургууль болгох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. 2018 он гэхэд интернэт холболттой бүх дунд сургуулийг сургалтыг дэмжих мэдээллийн үйлчилгээгээр бүрэн хангана;

8.1.5. ерөнхий боловсролын сургуулийн сурагч, багш нарт зориулсан компьютер, таблет, гар утас зэрэг бүх төрлийн мэдээлэл, холбооны хэрэгслийн орчинд ажиллах боловсрол, сургалтын программ хангамжийг хөгжүүлнэ.

8.2. “Монгол хэл” төсөл

8.2.1. монгол хэл бичгийн нийтээр дагаж мөрдөх кирилл, уйгаржин бичгийн онлайн тайлбар толь бичиг хэрэглээнд нэвтрэнэ. 2014 онд 10000, 2015 онд 30000 үг бүхий онлайн тайлбар толь бичгийн хувилбарыг нийтийн хүртээл болгож, цаашдаа жил бүр өргөтгөн сайжруулж ажиллана;



8.2.2. монгол хэлний үндэсний шалгалтын системийг боловсруулах ажлыг системтэйгээр эхлүүлж, 2018 онд туршилтын байдлаар, 2020 онд хэрэглээнд бүрэн нэвтэрсэн байна;

8.2.3. монгол кирилл бичгийн үсгийн дүрмийн алдаа засах компьютерийн программ хангамжийг зохиож, бүх нийтийн хэрэглээнд ашигласан байна.

8.3. “Нээлттэй их сургууль” төсөл:

8.3.1. Гүүгэл (Google) корпорацийн дэмжлэгтэйгээр бүх их, дээд сургууль, коллежийн багш, оюутнуудыг дэлхийд хамгийн өргөн ашиглагддаг, үнэ төлбөргүй, нээлттэй, сургалтын багц үйлчилгээтэй болгоно. Энэ ажлыг 2014-2015 онд бүрэн хэрэгжүүлнэ;

8.3.2. онлайн сургалттай, насан туршийн боловсролын нээлттэй их сургууль байгуулах бэлтгэлийг ханган ажиллаж, сургалтыг 2020 онд эхлүүлнэ.

8.4. “Үнэн түүх” төсөл

8.4.1. монголын түүхийн эх сурвалж, баримт бичиг, түүх, соёлын биет болон биет бус өв дурсгал, нотлох баримтуудыг цахим хэлбэрт шилжүүлж, түүхэн эх сурвалжийн онлайн, нээлттэй санг байгуулж 2018 онд үйл ажиллагааг нь эхлүүлнэ;

8.4.2. иргэд, олон нийтэд зориулсан монголын түүх, соёлын тухай танин мэдэхүйн баримтат, уран сайхны хөтөлбөрүүдийн тоогоор хэмжигдэнэ;

8.4.3. монголын түүх, соёлын тухай видео, онлайн нээлттэй мэдээллийн санг англи, орос, хятад болон дэлхийн бусад голлох хэл дээр гаргасан тоогоор хэмжигдэнэ.

8.5. “Үндэсний соёл” төсөл:

8.5.1. Монголпедиа онлайн нэвтэрхий толийн эхний хувилбарыг 2015-2016 онд бүтээж олон нийтийн оролцоотойгоор, нээлттэй өөрчлөн шинэчилж байх ажлыг зохион байгуулан ажиллана;

8.5.2. олон улсын нээлттэй сайтад тавигдсан Монгол Улсын нийгэм, эдийн засгийн талаар жилд 100-аас доошгүй нийтлэл, материал нэмж оруулна;



8.5.3. Монголын виртуал галлерейг 2018 онд, Монголын виртуал музейг 2020 онд байгуулж бүх нийтийн хүртээл болгоно.

8.6. “Нээлттэй мэдлэг” төсөл

8.6.1. эрдмийн бүтээл, диссертац, дипломын ажлын үндэсний нээлттэй сангийн онлайн системийг 2018 онд туршилтын байдлаар, 2020 онд бүрэн хэмжээгээр ашиглалтад оруулна;

8.6.2. дэлхийн шинжлэх ухааныг монголын эрдэмтэн, судлаачдад нээж, Томсон Ройтерс (Thomson Reuters) корпорацийн “Web of science”, “Web of knowledge”, “Community of science” болон Скопус (Scopus), Шпрингер (Springer)-ийн шинжлэх ухааны мэдээллийн санд нэвтрэх эрх авсан тоогоор хэмжигдэнэ.

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакци.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 6.25

Индекс: 14003